



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/477

Булган сум

Г Газар эзэмших эрх шилжүүлэх тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Т.Ганбат (ГЮ86082717)-ын Булган сум 6 дугаар баг Залуус 16 дугаар гудамж 1632 тоотод байршилтай 6308007409 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 870 м2 газрын газар эзэмших эрхийг А.Загд (ГМ60050102)-д, Р.Батхишиг (ГЮ74041261)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 6 дугаар гудамж 602а тоотод байршилтай 6308009721 нэгж талбар бүхий амины орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 3750 м2 газрын газар эзэмших эрхийг Э.Шинэхүү (ГЮ85012419)-д тус тус шилжүүлэн 14 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. А.Загд, Э.Шинэхүү нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Булган сумын Засаг даргын 2013 оны А/107 дугаар захирамж, аймгийн Засаг даргын 2024 оны А/470 дугаар захирамжийн Р.Батхишигтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

